



# Э-СОНИН

Монголын хөрөнгийн бирж  
Тусгай дугаар

2013 он • 8 сар

## ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТУХАЙ



Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга Улсын Их Хурлын 2013 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар батлагдсан бөгөөд тус хууль **2014 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөнө.**

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар дотоодын үнэт цаасны зах зээлийн хөгжлийн чиг хандлагыг олон улсын нийтлэг жишигт нийцүүлэх, үнэт цаасны зах зээлд оролцогчдын үйл ажиллагааг тодорхой зохицуулах, зах зээлийн үйл ажиллагааг ил тод болгох, олон нийт, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, төрийн зохицуулалт, хяналт, шалгалтын үр нөлөөг дээшлүүлэх чиглэлээрх хууль эрх зүйн орчныг бүрдүүлэхээр зорьсон байна.

Олон улсын стандартад нийцүүлэн гаргасан энэхүү хууль нь манай хууль эрх зүйн орчинг олон улсад хүлээн зөвшөөрөх томоохон алхам болсон юм.

### Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар:

**“Биржийн бус зах зээл”** буюу OTC зах зээлийг хуулиар зөвшөөрсөн. Биржийн бус зах зээл гэдэг нь санхүүгийн хэрэгсэлийг харилцан шууд худалдах, худалдан авах гэрээ байгуулах ажиллагаа явуулж байгаа зах зээлийн харилцаа юм.

Олон улсын жишгийн дагуу үнэт цаасны арилжааны төлбөр тооцооны дараа төлбөрт системийн тухай зохицуулалт тус хуулинд мөн орсон. Үнэт цаасны арилжааны төлбөрийн гүйлгээг тухайн **арилжаа явагдсанаас хойш ажлын гурван /3/ өдөрт багтаан гүйцэтгэхээр** хуулинд заасан. Өөрөөр хэлбэл, арилжаанд оролцогчид үнэт цаас худалдан авсан өдрөөс хойш арилжааны төлбөр тооцоог ажлын 3 өдөрт багтаан хийх боломж олгож, үнэт цаас эзэмших эрхийг төлбөр бүрэн төлөгдсөний дараа шилжүүлэх үндсэн зарчимтай байх юм.

**Кастодианы үйл ажиллагаа:** үнэт цаас өмчлөгчийн өмчлөл дэх үнэт цаасыг хадгалах, үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх бусад эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой үйлчилгээг үзүүлэх ажиллагааг хэлнэ. Кастодианы үйл ажиллагаа эрхлэх журмыг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо /Хороо/ хамтран тогтооно. /хуулийн 46 дугаар зүйлээс харах/

Үнэт цаасны зах зээл жинхэнэ сонгодог утгаараа хөгжих эрх зүйн орчинг энэхүү хуулиар бий болгож буй юм. Жишээ нь, аливаа улсад үнэт цаасны зах зээлийн гол тоглогч нь **мэргэжлийн хөрөнгө оруулагч** байдаг. Мэргэжлийн хөрөнгө оруулагч гэдэгт тэтгэврийн сан, хөрөнгө оруулалтын сан /нээлттэй, хаалттай/-гууд, даатгалын сангууд, хөрөнгө оруулалтын банкууд хамаардаг. Хуулийн шинэчилсэн найруулгад хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа, төрлийг зааж өгсөн бөгөөд нарийвчилсан зохицуулалтыг холбогдох хуулиар зохицуулахаар заасан байна. /хуулийн 38 дугаар зүйлээс харах/


## ҮНЭТ ЦААС ГАРГАГЧДАД ЧИГЛЭСЭН ЗОХИЦУУЛАЛТУУД

Үнэт цаасыг нийтэд санал болгох, эсхүл нийтэд санал болгохгүйгээр хаалттай хүрээнд худалдахаар гаргаж болохоор тус хуулинд заасан.

Үнэт цаасыг Монгол Улсын нутаг дэвсгэрт, эсхүл гадаад улсын нутаг дэвсгэрт арилжихаар гаргаж болохоор тусгасан нь үнэт цаас гаргагчдын хувьд дотоодын болоод гадаадын зах зээл дээрээс зэрэг хөрөнгө босгох боломжийг олгож байна. Одоогийн мөрдөгдөж буй хуулинд давхар бүртгэлийн асуудал зохицуулагдаагүй байдаг. Энэ нь хөрөнгийн шинэ, хямд эх үүсвэр татгах нөөц бололцоог хязгаарлаж байсан юм. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын дагуу **Давхар бүртгэлтэй** холбоотой нарийвчилсан зохицуулалтыг Хорооноос тогтоосон журмын дагуу хийнэ.

Хуулийн дагуу дотоодын үнэт цаас гаргагчид **Хадгаламжийн бичиг /DR/** гаргах замаар олон улсын зах зээл дээрээс хөрөнгө босгох боломжтой бөгөөд гадаад улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй хуулийн этгээд дотоодын хөрөнгийн биржид бүртгүүлэн үнэт цаас арилжих боломжтой боллоо. Олон улсын зах зээлд хөгжөөд тодорхой хугацаа өнгөрсөн энэхүү хэлбэрийн үнэт цаасыг гаргах боломж шинэ хуулиар олгогдож байгаа нь томоохон шинэчлэлт хийгээд давуу тал болж байна. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар Хадгаламжийн бичгийг гаргах ерөнхий зохицуулалт орсон бөгөөд нарийвчилсан зохицуулалтыг Хорооноос тогтоосон журмаар зохицуулахаар заажээ. Гадаадын үнэт цаас гаргагчид тавих шалгуур, шаардлага, гадаад улсын хөрөнгийн биржийн жагсаалтыг Хороо тогтоохоор заасан байна.

[/хуулийн 17, 18 дугаар зүйлээс харгах/](#)



Дээрх бүтээгдэхүүнээс гадна олон төрлийн **үүсмэл санхүүгийн хэрэгсэлийг** гарган арилжих боломжийг хуулиар зөвшөөрсөн. Үүсмэл үнэт цаас гэдэг нь өөрийн үнэ цэнийг үнэт цаас, актив, индекс эсвэл хүү зэрэг суурь зүйлүүдээс үүсгэдэг санхүүгийн хэрэгсэл юм.

[Дэлгэрэнгүй мэдэлийг хуулийн 5, 19 дугаар зүйлүүдээс авна уу.](#)

Шинэчилсэн хуулиар **үнэт цаасны танилцуулгад** тусгах мэдэлийг тодорхой зааж өгсөн нь үнэт цаас гаргагчдад хууль, дүрэм, журмаар хүлээсэн “нээлттэй ил тод байх” үүргээ биелүүлэхэд дөхөм болж байгаа хийгээд аливаа мэдээлэл, танилцуулгыг бүрэн бүрэлдүүлж, үнэт цаасыг бүртгүүлэх ажиллагааг хялбарчилж өгч байна.

[/хуулийн 10 дугаар зүйлээс харгах/](#)

Үнэт цаас гаргагч дангаар, эсхүл зохицуулалттай этгээдтэй байгуулсан гэрээний үндсэн дээр үнэт цаасаа үнэт цаасны анхдагч зах зээлд худалдахаар 50 ба түүнээс дээш тооны хөрөнгө оруулагчид танилцуулах, сурталчилах замаар санал болгоно.

Хороо нь үнэт цаасыг бүртгүүлэх тухай хүсэлтийг үнэт цаасны танилцуулга, бусад баримт бичгийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 20 өдрийн дотор хянаж шийдвэрлэхээр заасан нь одоогийн мөрдөгдөж буй хуулиар ажлын 30 хоног гэж зааснаас бага хугацаанд хянан шийдвэрлэхээр заасан. Түүнчлэн, үнэт цаасыг бүртгүүлэх тухай хүсэлтийг Хороо болон Хөрөнгийн бирж зэрэг шалгах боломж ч тус хуулиар бүрэлдсэн давуу талтай байна. Ингэснээр манай зах зээлд гарах үнэт цаасыг цаг алдалгүй нэгэн зэрэг шалгах боломжтой юм.

Үнэт цаас гаргагчид хуулийн дагуу компанийнхаа үйл ажиллагаа, санхүүгийн байдлын талаар **мэдээлэх үүрэгтэй** юм. Шинэ хуулиар мэдээллийн нээлттэй ил тод байдлыг сайжруулах зорилгоор үнэт цаас гаргагчид мэдээлэх үүргийн талаар дэлгэрэнгүй зааж өгсөн. Иймд, үнэт цаас гаргагчид тогтмол болон тухай бүр мэдээлэх мэдээллийн талаар илүү мэдээлэлтэй байж хууль, дүрэм, журмаар хүлээсэн олон нийтэд мэдээлэх үүргээ биелүүлэхэд хялбар болж байна.

[/хуулийн 20, 21, 55-56 дүгээр зүйлээс харгах/](#)

## ЗОХИЦУУЛАЛТТАЙ ЭТГЭЭД

Зохицуулалттай этгээд гэдэгт үнэт цаасны дилерийн, хөрөнгө оруулалтын зөвлөхийн, итгэмжлэн удирдах, андеррайтерийн, өмчлөх эрхийн бүртгэлийн, арилжааны тооцооны, арилжааны төлбөрийн, төвлөрсөн хадгаламжийн, кастодианы, арилжаа эрхлэх, хөрөнгө оруулалтын сангийн, хөрөнгө оруулалтын менежментийн, санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох, үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх, хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх, аудитын үйлчилгээ үзүүлэх, Хорооноос зохицуулалттай гэж тооцсон бусад үйл ажиллагааг хамаарахаар заажээ. Зохицуулалттай этгээдэд тавих нөхцөл, шаардлагыг Хорооноос тогтоож зөвшөөрөл олгоно.

Дор дурдсан зохицуулалттай үйл ажиллагааг хавсран эрхлэх боломжтойгоор шнэ хуулинд тусгажээ. Үүнд:

- Брокерийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд дилерийн болон андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагааг,
- Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд кастодианы, тооцооны болон төлбөрийн үйл ажиллагааг,
- Кастодианы үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд төлбөрийн үйл ажиллагааг,
- Тухай бүр Хорооноос зөвшөөрсөн үйл ажиллагаа.

### Зохицуулалттай үйл ажиллагаа:

Зохицуулалттай этгээд	Үйл ажиллагаа
Үнэт цаасны брокер	Харилцагчийн хөрөнгөөр, түүний нэрийн өмнөөс, түүний даалгавраар үнэт цаасыг худалдах, худалдан авахтай холбоотой зуучлалын үйлчилгээг гэрээний үндсэн дээр эрхлэх
Үнэт цаасны дилер	Өөрийн нэрийн өмнөөс өөрийн хөрөнгөөр үнэт цаасыг худалдах, худалдан авах ажиллагаа
Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа	Хөрөнгө оруулагчийн эрх ашгийг бүрэн төлөөлж ажиллах, сангийн хөрөнгийг үр ашигтайгаар өсгөн нэмэгдүүлэх зорилготой
Үнэт цаасны хөрөнгө оруулалтын зөвлөх	Үнэт цаас гаргагчийн нийтэд танилцуулагдсан мэдээлэл дээр үндэслэн судалгаа, шинжилгээ гүйцэтгэх, харилцагчид үнэт цаасыг худалдах, худалдан авах үнэ, нөхцөл, хугацааны талаар мэргэжлийн зөвлөгөөг төлбөртэйгээр өгөх ажиллагаа
Үнэт цаасны итгэмжлэн удирдах үйл ажиллагаа	Итгэмжлэгч харилцагчийн үнэт цаас, түүнтэй холбоотой хөрөнгийн өмчлөх эрхийг хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд заасан хязгаарын хүрээнд хэрэгжүүлэх
Андеррайтер	Үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээний үндсэн дээр түүний үнэт цаасыг нийтэд санал болгон гаргахад мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх, үнэт цаас гаргагчийн үнэт цаасны анхдагч зах зээлд худалдагдаагүй үлдсэн үнэт цаасыг андеррайтерийн гэрээнд заасан хэмжээгээр худалдаж авах
Үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэл	Үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээний үндсэн дээр үнэт цаасны өмчлөх эрх шилжүүлэхтэй холбоотой мэдээллийг хүлээн авч үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн мэдээллийн санд оруулан, уг мэдээллийг хадгалах, боловсруулах, хууль тогтоомжийн дагуу тайлагнах
Үнэт цаасны арилжааны тооцооны	Үнэт цаасны арилжааны дараа арилжаанд оролцогч талуудын гэрээ, хэлцлийн дагуу төлбөл зохих төлбөрийг гэрээ тус бүрээр болон нэгдсэн байдлаар тодорхойлж, холбогдох санхүүгийн бүртгэл, тооцооллыг хийх, Төлбөр хийгдэх бэлтгэлийг ханган, төлбөр гүйцэтгэх даалгаврыг эрх бүхий төлбөрийн байгууллагад илгээх
Үнэт цаасны арилжааны төлбөрийн	Тооцооны байгууллагаас ирүүлсэн даалгаврын дагуу үнэт цаас худалдан авагчаас төлөх төлбөрийг үнэт цаас худалдагчийн дансанд шилжүүлэх, Үнэт цаас худалдагчийн дансанд байгаа зохих тооны үнэт цаасыг худалдан авагчийн дансанд байршуулах, Кастодианы төвлөрсөн хадгаламжийн болон мөнгөн хөрөнгийн хадгаламжийн байгууллага хооронд даалгавар илгээх замаар төлбөрийн гүйлгээг тогтоосон хугацаанд нэгэн зэрэг гүйцэтгэх, Төлбөр төлөгдсөн тайлангийн дагуу зохих санхүүгийн бүртгэлийг гүйцэтгэн гүйлгээг баталгаажуулах, Зохих мэдээллийг үнэт цаасны хадгаламж, бүртгэлийн байгууллагад илгээх.
Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн	Үнэт цаас гаргагч болон бусад оролцогчтой байгуулсан гэрээний үндсэн дээр үнэт цаасыг хадгалах, түүнтэй холбоотой бүртгэл хөтлөх
Кастодиан	Үнэт цаас өмчлөгчийн өмчлөл дэх үнэт цаасыг хадгалах, үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх бусад эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой үйлчилгээг үзүүлэх
Үнэт цаасны арилжаа эрхлэх	Үнэт цаас болон үүсмэл санхүүгийн хэрэгслийг нийтэд санал болгон худалдах, худалдан авахтай холбоотой гэрээ, хэлцэл байгуулах нөхцлийг бүрдүүлж, үнэт цаасны арилжааг зохион байгуулах
Санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох	Үнэт цаас гаргагчийн санхүүжих чадавхын зэрэглэлийг тусгайлан боловсруулсан аргачлалд үндэслэн тогтоох хөндлөнгийн, хараат бус ажиллагаа


[Зохицуулалттай этгээд тус бүртэй холбоотой зохицуулалтыг хуулийн 24-54 дүгээр заалтуудаас үзнэ үү.](#)

## ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДАД


“Номиналь эзэмшигч” болон “бенефициар өмчлөгч”-ийн тухай зохицуулалт оруулсан. Шинэ хуулиар зөвшөөрөгдсөн хадгаламжийн бичиг зэрэг зарим бүтээгдэхүүнийг авах тохиолдолд “Номиналь эзэмшигч” болон “бенефициар өмчлөгч” гэсэн нэр томъёонууд зайлшгүй хэрэглэгдэх юм. Бенефициар өмчлөгч гэж тухайн үнэт цааснаас үүсэх үр шимийг хүртэх эрхтэй жинхэнэ өмчлөгчийг хэлж байгаа бол номиналь эзэмшигч гэж тухайн үнэт цаасны хадгалагчаар бүртгэгдсэн зохицуулалттай этгээдийг хэлнэ.

Хуулинд **нөлөө бүхий хувьцаа эзэмшигч** гэж тухайн компанийн гаргасан саналын эрхтэй нийт хувьцааны тав (5) болон түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл холбогдох этгээдийн хамт эзэмшиж байгаа болон тэдгээрийн саналын эрхийг хууль болон гэрээнд заасны дагуу хэрэгжүүлж байгаа иргэн, хуулийн этгээдийг хэлнэ. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч нь өөрийн өмчлөлд өөрчлөлт орсон даруйд холбогдох байгууллагад тайлагнах үүрэгтэй юм.


Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар хөрөнгө оруулагчдад санал болгох бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл нэмэгдсэний зэрэгцээ тэдгээрийн эрх ашгийг хамгаалахтай холбоотой зохицуулалтууд мөн орсон. Тухайлбал,

 Шинэ хуулиар зөвшөөрөгдсөн бүтээгдэхүүнүүд:


- Хувьцаа, компанийн өрийн хэрэгсэл, Засгийн газар, аймаг, нийслэлийн Засаг даргын гаргасан өрийн хэрэгсэл,
- Хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа, нэгж эрх,
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас
- Варрант
- Хадгаламжийн бичиг
- Давхар бүртгэлийн замаар дотоодын зах зээлд бүртгэгдсэн олон улсын компанийн үнэт цаас

 Нийтэд санал болгон үнэт цаас гаргах үед хөрөнгө оруулагчдыг илүү мэдээлэлтэй байлгах, тэднийг хамгаалахтай холбогдуулан Үнэт цаасны танилцуулгад заавал тусгасан байх мэдээлэл, IPO хийх үеэр олон нийтэд мэдээлэл үүргийн талаарх зохицуулалт шинэ хуулинд оржээ. Үнэт цаасны танилцуулгад тусгасан мэдээллийн үнэн зөв, хүчин төгөлдөр эсэхийг хууль зүйн зөвлөгөө үзүүлэх үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд, санхүүгийн мэдээлэл нь үнэн зөв эсэхийг аудитын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд тус тус хянаж, дүгнэлт гаргана.

[Үнэт цаасны танилцуулгад ямар мэдээлүүд тусгагдсан байх талаарх дэлгэрэнгүй жагсаалтыг хуулийн 10 дугаар зүйлээс үзнэ үү.](#)

 Компанийн хувьцааны хяналтын багцыг худалдан авах саналын хүчинтэй байх хугацааг 6 сар байсныг шинэ хуулиар 1 (нэг) сараас доошгүй, 3 (гурван) сараас дээшгүй байхаар заасан байна. Хуулиар компанийн хяналтын багцыг худалдан авах этгээдийн нийтэд хүргэх мэдээлэл, мэдээлэх үүргийн талаар тусгайлан зүйл, заалт оруулсан. Санал гаргагчийн хувьцаа худалдан авахаар санал болгох үнэ нь тухайн хувьцааны зах зээлийн үнээс доошгүй байна.

[Дэлгэрэнгүй зохицуулалтыг хуулийн 22, 23 дугаар зүйлээс харна уу.](#)

 Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар ойролцоогоор 14 орчим үйл ажиллагааг зохицуулалттай үйл ажиллагаа гэж үзэж Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл авсаны үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулахаар заасан. Хуулинд зохицуулалттай этгээдэд тавигдах шалгуур, шаардлага, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлсон бөгөөд нарийвчилсан зохицуулалтыг Хорооны багц дүрэм, журмаар хийхээр тусгажээ. Ерөнхийдөө, хөрөнгө оруулагчдын эрх, ашгийг хамгаалах зорилгоор зах зээлийн оролцогчдын хариуцлагыг өндөржүүлэх, мэдээлэх үүргийг сайжруулах, үйл ажиллагаа эрхлэх шаардлагыг хангахуйц хүний нөөцтэй байх зэрэг заалтуудыг оруулсан байна.

[Хуулийн 24-26 дугаар зүйлээс харна.](#)

## ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД ХОРИГЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

### Дотоод мэдээлэл ашиглан арилжаанд оролцохыг хориглоно:

Тодорхой үнэт цаасны үнэ ханшид нөлөөлөх нийтийн хүртээл болоогүй мэдээллийг дотоод мэдээлэл гэнэ. Үнэт цаас гаргагчийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан, ажилтан болон тэдгээрийн холбогдох этгээд, албан үүргээ хэрэгжүүлэх, гэрээ, хэлцлийн бэлтгэл болон түүнийг байгуулах, гүйцэтгэх үе шатанд дотоод мэдээллийг олж авсан этгээд болон тэдгээрийн холбогдох этгээдийг дотоод мэдээлэл эзэмшигч гэж үзнэ гэжээ. Дотоодод мэдээлэл эзэмшид хориглох зүйл болон дотоод мэдээллийг нийтэд мэдээлэхтэй холбоотой [дэлгэрэнгүй мэдээллийг хуулийн 77-79 дүгээр зүйлээс үзнэ үү.](#)

### Зах зээлийг урвуулан ашиглахыг хориглоно:

Үнэт цаасны зах зээлд хуурамч арилжаа хийх, үнэт цаасны үнэ ханшийг зохиомлоор тогтоох, үнэт цаасны зах зээлд оролцогч, харилцагчийг хууран мэхлэх замаар арилжаанд оролцуулах, эсхүл оролцуулахгүй байх болон бусад арга хэлбэрээр үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглахыг хориглоно.

Дотоод мэдээллийг ашиглан үнэт цаасны арилжаанд оролцсон, дотоод мэдээллийг зохих журмын дагуу нийтэд мэдээлээгүй, зах зээлийг урвуулан ашигласны улмаас бусдад учруулсан хохирлыг буруутай этгээд нөхөн төлөх үүрэгтэй талаар мөн хуулинд заажээ.

[/Хуулийн 80, 81 дүгээр зүйлээс харах/](#)

## ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ХЯНАЛТ, ШАЛГАЛТ

Хуулийн дагуу үнэт цаасны зах зээлийн гол зохицуулагч байгууллага нь Санхүүгийн зохицуулах хороо байна. Хороо бүрэн эрхээ хэрэгжүүлэх, эсхүл гадаад улсын эрх бүхий зохицуулагч байгууллага болон олон улсын байгууллагын хүсэлтэд заасан шаардлагатай мэдээллийг тогтоосон хугацаанд, шаардсан хэлбэрээр баталгаажуулж ирүүлэхийг зохицуулалттай этгээд, үнэт цаас гаргагч, тэдгээрийн холбогдох этгээд болон тухайн нөхцөл байдалтай холбоотой аливаа этгээдээс бичгээр шаардаж болно. Хороо нь зохицуулалттай этгээд, үнэт цаас гаргагч нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, түүнд нийцүүлэн Хорооноос гаргасан дүрэм, журмыг мөрдөж байгаа эсэхэд байнгын хяналт тавина.

[/хуулийн 61-66, 82-87 дүгээр зүйлээс харах/](#)



## МАРГААН ТАСЛАХ ЗӨВЛӨЛ

Хороо нь зохицуулалттай этгээд, үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагч, харилцагчийн хооронд гарсан маргааныг хянан шийдвэрлэх эрх бүхий Маргаан таслах зөвлөлтэй байх бөгөөд уг зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагааны журмыг Хороо батална.

## ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Хорооны хянан шалгагч үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол мөнгөн торгууль оногдуулахаар заажээ. Шинэчлэн найруулсан хуулийн хүрээнд мөнгөн торгуулийг 200, 300 дахин нэмэгдүүлж 86,400,000 төгрөг буюу ойролцоогоор \$59,000 болгосон байна.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад зах зээлийн одоогийн зохицуулалтыг нэмэгдүүлж, олон улсын жишгийн дагуу бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл, нэр томъёог оруулсан нь зах зээлд шинэ дэвшлийг авчрах, дотоодын зах зээл илүү нээлттэй ил тод бөгөөд харилцагчдын итгэлийг хүлээсэн зах зээл болох улмаар зах зээлийн хөгжил олон улсын нийтлэг жишигт хүрэх юм. Хуулийн дагуу өөрийгөө зохицуулах байгууллагууд үйл ажиллагаандаа мөрдөх дүрэм, жумыг тогтоох, гишүүдийнхээ чадавхийг дээшлүүлэх, үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх, тогтвортой байдлыг хангах зорилготойгоор зохицуулагдсан. Иймд хуулийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд зах зээлд оролцогч бүрийн оролцоо, хүчин чармайлт чухал юм.